



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 01

Сүхбаатар сум

Дотоод аудитын хорооны 2025 оны анхдугаар хуралдаан

Дотоод аудитын хорооны хурал 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 09:00 цагт Засаг даргын хурлын өрөөнд эхэлж А.Дашбат гишүүн сумдаар албан томилолтой тул хуралд оролцоогүй, хурлын ирц 85.7 хувьтай хуралдаж 12:00 цагт дууссав.

Хуралд:

Дарга:	Н.Лхагвадорж
Нарийн бичгийн дага:	Т.Мөнхзул
Гишүүд:	Ө.Сувдаа
	Т.Одсүрэн
	Х.Мөнхжаргал
	Б.Янжинхлам
	А.Гэрэлмаа

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. 2024 онд хийгдсэн хяналт шалгалтын үр дүн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлт
2. Дотоод аудитын 2025-2028 оны дунд хугацааны төлөвлөгөө
3. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө
4. 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө
5. Бусад цаг үеийн асуудал

2024 онд хийгдсэн хяналт шалгалтын үр дүн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийн талаар:

СОНССОН НЬ:

Т.Одсүрэн: 2024 онд хийгдсэн хяналт шалгалтын үр дүн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийн талаар та бүхэнд танилцуулъя.

2024 онд 19 дотоод аудит 25 санхүүгийн хяналт шалгалт нийт 44 хяналт шалгалт хийгдэж 22,323.0 сая төгрөгийн 378 зөрчил илрүүлснээс 280.7 сая төгрөгийн 20 төлбөрийн акт, 17,012.6 сая төгрөгийн 148 албан шаардлага, 5,029.7 сая төгрөгийн 182 зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Хяналт шалгалтын хэрэгжилт нь төлбөрийн

акт 182.9 сая төгрөг 64.9 хувиар албан шаардлага 12,031.5 сая төгрөг 70.7 хувийн 3,717.3 сая төгрөг 71.4 хувийн биелэлттэй байна.

Оны сүүлээр 4 дүгээр улиралд хийгдсэн хяналт шалгалтын хэрэгжилтийн хугацаа болоогүй байснаас мөн Сүхбаатар сумын ХХС-ийн 2011 оноос хойш олгосон хугацаа хэтэрсэн зээлүүдийн алданги тооцсон төлбөрийн актын биелэлт гүйцэд барагдуулаагүйгээс шалтгаалсан.

Н.Лхагвадорж: Удирдлага солигдсоноос хойш танай албаны ажил сайжирч байгаа тийм ч учраас бид боломжоороо дэмжин ажиллаж байгаа. Хэдэн ААТҮГ-удыг шалгасан бэ. Голчлон ямар зөрчлүүд гарч байна.

Т.Одсүрэн: Төлөвлөгөөнд тусгагдсан Сайхан сумын Гавшгай-Ус ААТҮГ, Мандал сумын Тохилог хараа ОНӨААТҮГ, Сүхбаатар сумын Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ болон өргөдөл гомдлоор Сайхан сумын Хот тохижилтын газрыг шалгасан. Хяналт шалгалт хийсэн дотоод аудиторуд танилцуулна уу.

Т.Мөнхзул: Өргөн Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ-нь нийтийн зам талбайн гэрэлтүүлэг, нийтийн тээвэр, мал нядалгаа, журмын хашаа, Сайханы хөтлийн тохижилт үйлчилгээ, олон улсын худалдааны төвийг хариуцан ажиллаж Сүхбаатар сумаас жилд 600.0 -аад сая төгрөгийн санхүүгийн татаас авдаг ч алдагдалтай ажилласан байсан. Олон улсын худалдааны төв нь зах зээлийн ханшаас хамаагүй бага дүнгээр талбайн түрээсийг тогтоосноос орлогоосоо давсан зардал гаргадаг, 2021 онд аймгийн ОНХС -ийн хөрөнгө болох 779.0 сая төгрөгийн баригдаж ашиглалтад орсон Сайханы хөтлийн цогцолборын байгууламжуудыг санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй орлого аваагүй, Сайханы хөтлийн үзэж сонирхохоор ирж байгаа автомашины хураамжийн бүртгэл сул татварын цахим баримт олгодоггүй, нийтийн бие засах газрыг зориулалт бусаар тохижуулж цайны газар болгон иргэн ажиллуулж байгаа гэх мэт 9 зөрчилд албан шаардлага, зөвлөмжүүдийг хүргүүлэн ажилласан.

Г.Дорждэрэм: Гавшгай-Ус ААТҮГ-ыг дотоод аудитор Х.Батбаатарын хамт шалгасан. Сайхан сумын аж нэгж байгууллагуудаас усны төлбөрийн он дамжсан 1,910.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах тал дээр санаачлаагүйг ажиллаж анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулалтууд хийгдсэн, худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй шууд худалдан авалт хийдэг, ашиглах боломжгүй хуучирсан гэмтэлтэй үндсэн хөрөнгүүд бүртгэлтэй, элэгдлийг буруу тооцож бүртгэлд тусгасан нийт 13 зөрчилд 1 төлбөрийн акт, 6 албан шаардлага 6 зөвлөмж хүргүүлж биелэлтийг тооцон ажилласан.

А.Гэрэлмаа: Гэрээгээр хөндлөнгийн аудит хийж байхад ААТҮГ- уд алдагдалтай ажиллаж байгаа нэг гол шалтгаан нь үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүн өндөр байдаг. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд дээр элэгдлийг шулуун шугамын аргаас өөрөөр тооцох боломж байдаг болов уу.

Х.Мөнхжаргал: Санхүүгийн бодлогын бичиг баримтдаа өөрчлөлт оруулах ажлын хэсэг гаргах тооцоо судалгаа хийх гээд нэлээд урт хугацааны ажил болох байх.

Ө.Сувдаа: Үйл ажиллагаа явуулахгүй байгаа өмчит газруудын үйл ажиллагаанд аудит хийж дүгнэлт гаргаж татан буулгах ямар боломж байна.

Т.Одсүрэн: Одоогоор 4 өмчит газар ямар ч үйл ажиллагаа явуулахгүй удсан хариуцах санхүүгийн ажилтангүй байгаа болохоор хяналт шалгалт оруулах боломжгүй. Харин аймгаас комисс гаргаж ажиллахад манай албанаас оролцож болно.

Н.Лхагвадорж: Хяналт шалгалтын хэрэгжилтийн дүнгээс харахад өндөр дүнтэй олон зөрчил гаргасан Сүхбаатар сумын ТТЗ болон ЗДТГ, ИТХ ажлын албаны зөрчлийн хэрэгжилт болон зөрчлийн жагсаалтыг гаргаж өгөөрэй. ААТҮГ-удыг бусад аймгийн ижил төстэй үйл ажиллагаатай газруудтай харьцуулсан судалгаа шинжилгээг хийх, ашиг орлогыг нь нэмэгдүүлэх боломж, алдагдлын шалтгаан дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна. Үйл ажиллагаа явуулахгүй байгаа ААТҮГ-удын судалгааг гаргаж өгөөрэй ИТХ-ын ажлын албанд танилцуулъя.

Х.Батбаатар: 2024 онд хийгдсэн шилэн дансны аудитын дүнг танилцууллаа.

ТЕЗ-ын эрхлэх хүрээний 128 байгууллагын шилэн дансанд улирал бүр дотоод аудит хийж тайлан гаргаж Сангийн яамны санхүүгийн хяналт эрсдэлийн удирдлын газар болон засаг даргад хүргүүлэн ажилласан.

2024 оны 4 улирын шилэн дансны аудитаар Сант, Мандал, Баруунбүрэн, Шаамар, Түшиг, Сайхан сум болон АОНХС сан хангалтгүй гэсэн үнэлгээ авсан.

Ө. Сувдаа: Энэ сумууд ямар шалтгаанаар мэдээлэл оруулахгүй байна.

Х.Батбаатар: ОНХС болон ХХС-ын мэдээлэл оруулах цэсээ нээгээгүй нээсэн ч огт мэдээлэл оруулаагүй байсан.

Н.Лхагвадорж: Аймгийн ОНХС-н цэс яагаад нээгдээгүй байна. Хэн хариуцаж байна.

Х.Мөнхжаргал: Сугардорж хариуцаж байгаа цэс нээлгэх хүсэлтээ онлайнаар илгээсэн гэсэн.

Дотоод аудитын 2025-2028 оны дунд хугацааны төлөвлөгөөний талаар:

Т.Одсүрэн: Монгол Улсын Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.1 дэх заалтын дагуу Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны "2025-2028 оны дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө"-г 4 зорилтын хүрээнд боловсруулж танилцуулга хийлээ. Дотоод аудитын хорооны гишүүд та бүхэнд төс хэвлэн тараасан байгаа саналаа хэлнэ үү.

Ө.Сувдаа: Төлөвлөгөөний төсөлтэй танилцлаа. Эрхэм зорилго алсын хараагаа зөв тодорхойлох, зарим шалгуур үзүүлэлтийг солихоор харагдаж байна. Би тараасан төлөвлөгөөний танилцуулгын материал дээр зассан байгаа.

Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 2025 онд хийх хяналт шалгалтын хуваарийн талаар

Т.Одсүрэн: 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг танилцуулаа. 2025 оныг дотоод аудитын удирдлагын мэдээллийн системийг цахимжуулалтыг төлөвшүүлэх жил болгон үндсэн чиг үүргийн хүрээнд 17 арга хэмжээ, нийтлэг чиг үүргийн хүрээнд 9 арга хэмжээг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Энэ онд 12 дотоод аудит, 21 санхүүгийн хяналт шалгалтыг хийхээр төлөвлөсөн. Өнгөрсөн онд 9 сумын ТТЗ, ЗДТГ, ИТХ-ын ажлын албадуудын үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн

хяналт шалгалт хийгдсэн Энэ онд үлдсэн 8 сумын ТТЗ, ЗДТГ, ИТХ-ын ажлын албуудад болон Засаг даргын харьяаны 3, сум дундын ойн ангиуд, Урсгал-ус Сэлэнгэ Энержи ААТҮГ-уудад дотоод аудит, хяналт шалгалтууд хийгдэнэ.

Ө. Сувдаа: Тус албанаас эрсдэлийн үнэлгээ хийж хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагуудын талаар мэргэжлийн хүмүүс нь хийсэн асуудал дээр санал алгаа.

Бусад цаг үеийн асуудлын талаар:

Т.Одсүрэн: Бидний ажлыг ойлгож дэмжин тоног төхөөрөмж болон бусад ажлуудад дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа Засаг дарга, тамгын дарга, хорооны гишүүддээ баярласан талархсанаа илэрхийлж хяналт шалгалт хийх байгууллагуудын төсөв санхүү урьд онуудаас 2-3 дахин нэмэгдэж хяналт хийх ачаалал тэр хэмжээгээр нэмэгдэж байхад манай байгууллагын 2025 оны батлагдсан төсөв цалингийн сан хүрэлцэхгүй байгаа 2024 онд гүйцэтгэлээр 9 албан хаагч ажиллаж байгаа гэтэл 7 орон тоогоор төсөв баталсан тухай тооцоо судалгааг танилцуулав.

Х.Мөнхжаргал: Хяналт шалгалтаар явах автомашины асуудлыг шийдүүлэх талаар сангийн яаманд танилцуулсан.

Ө.Сувдаа: Төсөвт тодотгол хийгдвэл энэ асуудлыг эргэн харж нааштайгаар шийдэж болно байх гэж бодож байна. Бид энэ албаныхаа үйл ажиллагааг дэмжиж ажилласнаар ТЕЗ-н харьяаны байгууллагуудын алдаа зөрчил багасаж санхүүгийн санхүүгийн сахилга бат сайжирна гэж бодож байна.

Т.Одсүрэн: Манай алба ажил үүргийн чиглэлийн дагуу 10 ажлын байрны тодорхойлолтын шинэчлэн боловсруулж төрийн албаны зөвлөлд явуулахаар бэлтгэж байгаа. Төрийн аудитаас Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтэд санал авахад манай байгууллагыг оролцуулж баймаар байна.

Ө.Сувдаа: Албаны хүний нөөцийн бодлого төлөвлөлт, хууль тогтоомж, үйл ажиллагааны онцлогтой нь уялдуулан дотоод аудитыг бэхжүүлэхэд өөрчлөх, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулахыг зарчмын хувьд дэмжиж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

- Дотоод аудитыг хөгжүүлэх 2025-2028 оны дунд хугацааны төлөвлөгөөг баталгаажуулах
- Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулах
- 2025 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг, хяналт шалгалтад хамрагдах байгууллагуудын жагсаалтыг тус тус баталгаажуулахаар шийдвэрлэв

ТАНИЛЦСАН:

ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ
ДАРГА

Н.ЛХАГВАДОРЖ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

СХШУАБ:

Т.МӨНХЗУЛ